

## ШИНЭ МЭДЭЭ

**МОНГОЛ, БНСУ-ЫН ЭРДЭМТДИЙН  
АНХДУГААР БАГА ХУРАЛ****Б. Лхагваа\***

Монголын ШУА-ийн Дорнодахин, олон улс судлалын хүрээлэн, БНСУ-ын Соганы Их сургуулийн санаачилгаар монгол, солонгосын эрдэмтдийн анхдугаар бага хурал 1991 оны 6-р сарын 25— 26-нд Улаанбаатар хотноо болов.

«Зүүн Азийн бүс нутгийн хамтын ажиллагаа: «БНМАУ, БНСУ» сэдэвт энэ хурлаар уг, бүс нутагт бүрэлдэн бий болсон шинэ нөхцөл байдалд хоёр орон, ард түмний харилцаа, хамтын ажиллагааг хэрхэн хөгжүүлэх, түүний хэтийн төлөв ямар байх талаар эрдэмтэд санал бодлоо солилцож, асуудал дэвшүүлсэн халуун яриа өрнүүлэв,

ШУА-ийн тэргүүн дэд ерөнхийлөгч доктор, профессор Б.Чадраа хурлыг нээж хэлсэн үгэндээ 700-гаад жил тасарсан хоёр ард түмний харилцаа өнгөрсөн онд дипломат харилцаа тогтоосноор сэргэж хоёр орны харилцаа, хамтын ажиллагаа түүний дотор, соёл, шинжлэх ухааны хэлхээ холбоо эхлэлийн байдалтай боловч идэвхтэй, эрчимтэй явагдаж буйг онцлон тэмдэглэв.

БНСУ-ын төлөөлөгчдийн тэргүүн, Солонгосын гадаад харилцааны нийгэмлэгийн ерөнхийлөгч, Соганы Их сургуулийн профессор И Сан Ү солонгос, монголчууд гарал угсаа нэгтэй гэсэн сэтгэлээр бие биедээ ойр дотно ханддаг сэтгэл зүйн үндэс суурь нь харилцаа, хамтын ажиллагааг бүхий л салбарт хөгжүүлэх сайхан боломж бүрдүүлж байна гэж цохон дурдав.

Хурал дээр Дорнодахин, олон улс судлалын хүрээлэнгийн захирал, дэд эрдэмтэн Ц.Батбаяр «Зүүн Азийн хамтын ажиллагааны шинэ эрин: БНМАУ ба БНСУ», БНСУ-ын парламентын гишүүн, доктор Жо Сүн Сын «Зүүн хойд Азийн шинэ нөхцөл байдал дахь Солонгос, Монголын харилцаа», профессор Ким Сү Ён «Солонгос, Монголын эдийн засгийн хамтын ажиллагаа: боломж, хэтийн төлөв», доктор профессор Х. Дашдондов «Монгол Солонгосын эдийн засаг, ШУТ-ийн хамтын ажиллагаа, хэтийн төлөв», профессор Ю Жэ Чөн «Солонгос, Монголын нийгэм, соёлын салбарын хамтын ажиллагаа», эрдэм шинжилгээний ажилтан, солонгос судлалын төвийн нарийн бичгийн дарга Б. Лхагваа «Монгол, Солонгосын улс төр, нийгэм соёлын салбарын харилцаа боломж: хэтийн төлөв» гэсэн илтгэлүүдийг тус тус тавьж хэлэлцүүлэв.

Эрдэмтэд, судлаачид олон улсын харилцааны өөрчлөлт Ази, Номхон далайн бүс нутагт нөлөөлж буйгаар үл барам дэлхийн хөгжлийн цөм уг бүс нутагт ирэх зуунд шилжих төлөвийг угтуулан бүс нутгийн аюулгүй байдлыг бататган, хамтын ажиллагааны механизмыг боловсронгуй болгохын чухлыг нухацтай авч хэлэлцэв.

Хуралд оролцогсод БНМАУ-ын Ази руу илүү чиглэсэн нээлттэй бодлого, БНСУ-ын «Умардын бодлого» бүс нутгийн хийгээд хоёр талын харилцаа, хамтын ажиллагаанд зохих нөлөө үзүүлж, бодитой үр дүнд хүрч буйг өндөр үнэлэв.

Мөн Монгол, БНСУ-ын харилцаа, хамтын ажиллагаа эхлэлийн шатанд байгаа хэдий ч улс төр, эдийн засаг, соёл шинжлэх ухааны хэлхээ холбоо, хамтын ажиллагаа эрчимтэй хөгжиж буй онцлог хадгалж байна гэсэн дүгнэлтэд хүрч түүнийг цаашид үр ашигтай хөгжүүлэх ар-

\*Б. Лхагваа — Дорнодахин, олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

га замуудыг эрэлхийлсэн саналуудыг дэвшүүлцгээв. Улс төрийн хүрээнд хоёр үндэстний эрх ашгийг хөндсөн зайлшгүй шийдвэрлэвэл зохих ямар нэг саад бэрхшээл байхгүй байгаа нь энэ чиглэлд харилцаа улам өргөжих сайхан ирээдүйг харуулж байна гэж тэд үзэв.

Түүнчлэн БНСУ-ын эдийн засгийн өндөр түвшинд хүрсэн хөгжил, шинжлэх ухаан техник, технологийн хүчин чадлыг Монголын түүхий эдийн нөөцтэй зөв хослуулах замаар эдийн засгийн өргөн талт хамтын ажиллагааны хэлбэрүүдээс зөв сонголт хийн харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх боломж, чиглэлтэй холбогдсон асуудлуудыг судалж байгаа явц, дэвшүүлж буй саналуудаа хоёр тал харилцан мэдэгдэв.

Нөгөөтэйгүүр өнө эртний харилцааны түүхэн уламжлал нь бусад салбарын нэгэн адил соёл, шинжлэх ухаан, олон нийтийн байгууллага, иргэдийн хэлхээ холбоо, хамтын ажиллагааг хөгжүүлэх бэлэн шимт хөрс, асар их нөөц боломж болж байгаа талаар эрдэмтэд, судлаачид нэгдсэн дүгнэлттэй байгаа нь харагдав. Шинжлэх ухаан, боловсрол, урлаг, утга зохиол, мэдээллийн салбарт хамтран ажиллах хэлбэрийн тухай олон сонирхолтой саналууд гарав.

Бүс нутгийн хийгээд хоёр талын харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар иймэрхүү эрдэм шинжилгээний хамтарсан хурал, семинарыг тогтмол зохиож байхаар хуралд оролцогсад тохиролцсоны гадна ШУА, Соганы Их сургууль, түүнчлэн ШУА-ийн Дорнодахин, олон улс судлалын хүрээлэн, Соганы Их сургуулийн Зүүн Азийн судлалын хүрээлэнгийн хооронд хамтран ажиллах протоколд гарын үсэг зурав. Энэ хуралд эрдэмтэд судлаачдын зэрэгцээгээр Солонгосын иргэний агаарын тээврийн «КАЛ» компанийн тэргүүн дэд ерөнхийлөгч доктор Чо Ян Хо, «РЕНХАП» Мэдээллийн агентлагийн ерөнхий редактор ноён Карл Чон Мун, «КИЯА» группийн гангийн үйлдвэрийн ахлах менежер ноён Чон Сан Кеи нарын зэрэг өндөр албан тушаалын хүмүүс оролцож манай ажил төрлийн холбоотой байгууллагуудтай хамтын ажиллагааны асуудал хэлэлцэж ярилцсан нь харилцааны практик үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой боллоо.